



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 38

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 5.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 3 нэрийн 292,965,890.83 (хоёр зуун ерэн хоёр сая есөн зуун жаран таван мянга найман зуун ерэн төгрөг наян гурван мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг Орхон аймгийн Онцгой байдлын газарт балансаас балансад шилжүүлж, цаашид ашиглах хугацаа, үнийг хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын ерөнхий захирал Х.Бадамсүрэн, Орхон аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Ганбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 569 дүгээр тогтоолоор баталсан хөрөнгийн жагсаалтаас “2”, “4”, “6” дугаарт заасан хөрөнгийг хассугай.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэст үүрэг болгосугай.

ДАРГА

3.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

Төрийн өмчийн бодлого, зохицшилалтын газрын  
2020 оны 04 сарын 7 -ний өдрийн  
28 дугаар тогтоолын хавсралт

**"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИЙТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРГЭЛТЭЙ  
ОРХОН АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАРТ БАЛАНСАД ШИЛЖУЛЭХ  
ЦААШИД АШИГЛАХ ХУГАЦАА, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТОХ ХӨРӨНГИЙН ЖАГСАЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа (жил)
1	Шатахуун тээвэрлэх (8 м.куб) Тусгай зориулалтын автомашин HINO, улсын дугаар ОРО 30-52	2011.12.31	ш	1	85,482,375.00	1,500,000	3
2	Бохир соруулах автомашин АС ЗИП-КО-510, улсын дугаар ОРА 99-02	2004.12.31	ш	1	34,540,036.02	1,000,000	1
3	УРАЛ-43206-10 автомашин, улсын дугаар ОРА 04-63	2005.08.31	ш	1	172,943,479.81	1,000,000	1
<b>Дүн</b>					<b>292,965,890.83</b>	<b>3,500,000.00</b>	
					(хоёр зуун өрэн хоёр сая есөн зуун жаран таван мянга найман зүүн өрэн төгрөг наян гурван мөнгө)	(гурван сая таван зуун мянга)	